

БАЯН ЖАНЖИН ХИШИГ АУДИТ ХХК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Увс аймгийн Шинэ Улаангом ОНӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: УВА-2026/005/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)  
Улаангом хот  
2026 он

Увс аймаг дахь Төрийн аудитын газар,  
Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь  
Утас: 70453317, Цахим хаяг: [BatsuuriM@audit.gov.mn](mailto:BatsuuriM@audit.gov.mn)  
Аудитын менежер: М.Бат-Амгалан  
Утас: 70453799, Цахим хаяг: [Bat-Amgalanm@audit.gov.mn](mailto:Bat-Amgalanm@audit.gov.mn)  
Гэрээгээр аудитыг гүйцэтгэсэн Баян жанжин хишиг аудит  
ХХК-ийн аудитор: А.Дугармаа  
Утас: 99542180, Цахим хаяг: [baynjanjinxishig@gmail.com](mailto:baynjanjinxishig@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	3
Дүгнэлтийн үндэслэл .....	3
Асуудлыг онцолсон хэсэг.....	4
Аудитын гол асуудал .....	4
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА .....	7
4.1 Ерөнхий зүйл .....	9
4.2 Материаллаг байдал.....	10
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	10
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	10
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	11
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	11

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
БШУЯ	Боловсрол, шинжлэх ухааны яам
ТШЗ	Төсвийн шууд захирагч
НА	Нийцлийн аудит



**УВС АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,  
Ө.Бадрахын гудамж  
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,  
E-mail: uvs@audit.gov.mn

УВС АЙМГИЙН ШИНЭ УЛААНГОМ  
ОНӨААТҮГ-ЫН ЗАХИРАЛ  
Б.БАТЦЭЦЭГ ТАНАА

2026-03-11 № УВА-2026/005/НА-СТА-ОНӨЧГ  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**Хязгаарлалтай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Увс аймгийн Шинэ-Улаангом ОНӨААТҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайланд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалтай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол Шинэ Улаангом ОНӨААТҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан бүх материаллаг талаар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Шинэ Улаангом ОНӨААТҮГ-ын Худалдааны төв шатсантай холбогдуулан эрх бүхий байгууллагын дүгнэлт, шийдвэр гараагүй тул үл хөдлөх хөрөнгийн бүртгэлд өөрчлөлт оруулаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтлана", 5.1.4-д "Үнэн зөв байх", 5.1.5-д "Хэмжигдэхүйц байх", 8.4-д "Аж ахуйн нэгж байгууллагын гүйцэтгэх удирдлага болон ерөнхий нягтлан бодогч санхүүгийн тайланд гарын үсэг зурж, тамга /тэмдэг/ дарж баталгаажуулах бөгөөд гүйцэтгэх удирдлага санхүүгийн тайлангийн үнэн зөвийг хариуцна", 20.2-д "Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ", 20.2.6-д "Хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай нийцэхгүй, Нийцсэн бөгөөд Зохистой батламж мэдэгдлийг хангахгүй байна.



8525050350

## **Асуудлыг онцолсон хэсэг**

АДБОУС 2706.7-д тодорхойлсноор асуудлыг онцолсон хэсэгт санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн ойлголтыг бүрдүүлэхэд ач холбогдолтэй, санхүүгийн тайланд толилуулсан, тодруулсан мэдээлэл байхгүй болно.

## **Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

## **Бусад асуудлын хэсэг**

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад санхүүгийн тайлангийн тодруулга толилуулгад тусгаагүй, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй асуудал гараагүй болно.

**Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.БАТСУУРЬ

С АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН АГЛАМ  
ХЯЗГААРЛАЛТЫН  
СЭВЭЛ ДҮГНЭЛТ

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### 2.1. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Төгрөгөөр /

Мерийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	<b>ХӨРӨНГӨ</b>	0.00	0.00
1.1	<b>Эргэлтийн хөрөнгө</b>	8,405,274.53	33,909,063.43
1.1.1	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	388,039.08	1,757,793.42
1.1.2	Дансны авлага	1,080,000.00	19,602,804.69
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	582,235.39	5,268,465.24
1.1.6	Бараа материал	2,080,000.08	7,280,000.08
1.1.7	Урьдчилж төлсөн зардал тооцоо	4,275,000.00	0.00
1.1.20	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	8,405,274.53	33,909,063.43
1.2	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>	0.00	0.00
1.2.1	Үндсэн хөрөнгө	1,704,447,228.32	1,561,730,678.20
1.2.2	Биет бус хөрөнгө	72,123,997.26	72,000,000.00
1.2.10	<b>Дүн</b>	1,776,571,225.58	1,633,730,678.20
1.3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	1,784,976,500.11	1,667,639,741.63
2	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>	0.00	0.00
2.1	<b>ӨР ТӨЛБӨР</b>	0.00	0.00
2.1.1	<b>Богино хугацаат өр төлбөр</b>	0.00	0.00
2.1.1.1	Дансны өглөг	5,200,000.00	50,121,973.06
2.1.1.2	Цалингийн өглөг	0.00	0.00
2.1.1.3	Татварын өр	62,071,878.68	61,095,761.64
2.1.1.4	НДШ-ийн өглөг	0.00	99,000.00
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	10,127,360.01	7,973,208.01
2.1.1.13	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	77,399,238.69	119,289,942.71
2.1.2	<b>Урт хугацаат өр төлбөр</b>	283,011,514.00	199,747,807.00
2.2	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	360,410,752.69	319,037,749.71
2.3	<b>Эздийн өмч</b>	0.00	0.00
2.3.1	Төрийн өмч	3,052,500,000.00	3,052,500,000.00
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	72,000,000.00	72,000,000.00
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	0.00	0.00
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	0.00	0.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	-1,699,934,252.58	-1,775,898,008.08
2.3.11	<b>Эздийн өмчийн дүн</b>	1,424,565,747.42	1,348,601,991.92
2.4	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>	1,784,976,500.11	1,667,639,741.63

## 2.2 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Мөрийн дугаар	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
1	<b>Борлуулалтын орлого ( цэвэр )</b>	<b>601,296,970.57</b>	<b>707,573,492.85</b>
2	Борлуулалтын өртөг		
3	<b>Нийт ашиг ( алдагдал )</b>	<b>601,296,970.57</b>	<b>707,573,492.85</b>
9	Борлуулалт, маркетингийн зардал	5,470,454.54	9,305,799.99
10	Ерөнхий ба удирдлагын зардал	593,540,092.97	697,686,756.96
11	Санхүүгийн зардал		161,900
12	Бусад зардал	2,000,000.00	76,340,887.84
18	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг ( алдагдал )</b>	<b>286,423.06</b>	<b>-75,921,851.91</b>
19	Орлогын татварын зардал		41,903.59
20	<b>Татварын дараах ашиг ( алдагдал )</b>	<b>286,423.06</b>	<b>-75,963,755.50</b>
22	<b>Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал )</b>	<b>286,423.06</b>	<b>-75,963,755.50</b>
24	<b>Орлогын нийт дүн</b>	<b>286,423.06</b>	<b>-75,963,755.50</b>
25	<b>Нэгж хувьцаанд ноогдох суурь ашиг ( алдагдал )</b>		

## 2.3 АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Мөрийн дугаар	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
i	<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	664,640,188.05	772,445,885.31
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсэний орлого	643,628,200.00	759,954,877.31
1.1.6	Бусад мөнгөн орлого	21,011,988.05	12,491,008.00
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	664,259,654.89	770,076,130.97
1.2.1	Ажиллагчдад төлсөн	151,541,116.00	177,608,446.03
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	41,500,000.00	48,119,385.58
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	208,005,037.00	217,897,948.74
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	215,173,768.39	227,125,441.63
1.2.5	Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	0.00	30,000.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	33,437,133.50	83,269,372.63
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	8,550,000.00	8,550,000.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	6,052,600.00	7,475,536.36
1.3	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>380,533.16</b>	<b>2,369,754.34</b>
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	-500,000.00	-1,000,000.00
3.1.3	Төрөл бүрийн хандив	-500,000.00	-1,000,000.00
3.3	<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>-500,000.00</b>	<b>-1,000,000.00</b>
5	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>-119,466.84</b>	<b>1,369,754.34</b>
6	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>507,505.92</b>	<b>388,039.08</b>
7	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>388,039.08</b>	<b>1,757,793.42</b>

## 2.4 АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/төгрөггөөр/

	Үндэслэлт дүгнэлт	Өмч Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нягтлан бодох дүн
1	2024 оны 01-р сарын 31-ээрх үлдэгдэл	3,052,500,000.00	72,000,000.00	-1,700,192,033.33	1,424,307,966.67
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.00	0.00	0.00	0.00
3	Залруулсан үлдэгдэл	3,052,500,000.00	72,000,000.00	-1,700,192,033.33	1,424,307,966.67
4	Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00	0.00	0.00
5	Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал )	0.00	0.00	0.00	0.00
6	Өмчид гаргасан өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
7	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	286,423.06	286,423.06
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0.00	0.00	0.00	0.00
9	2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	3,052,500,000.00	72,000,000.00	-1,699,934,252.58	1,424,565,747.42
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.00	0.00	0.00	0.00
11	Залруулсан үлдэгдэл	3,052,500,000.00	72,000,000.00	-1,699,934,252.58	1,424,565,747.42
12	Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00	0.00	0.00
13	Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал )	0.00	0.00	0.00	0.00
14	Өмчид гаргасан өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
15	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	-75,963,755.53	-75,963,755.53
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0.00	0.00	0.00	0.00
17	2025 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	3,052,500,000.00	72,000,000.00	-1,775,898,008.08	1,348,601,991.92

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Худалдаа эрхлэгчдийг дулаан, тав тухтай орчинд түрээсийн дарамтгүй бизнесээ явуулах, дотоод гадаадын худалдан авагчдыг чанартай бараа бүтээгдэхүүнээр хангах Олон Улсын Худалдааны Төв болох зорилго зорилтыг тавин ажилладаг.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Увс аймгийн Шинэ-Улаангом ОНӨААТҮГ-ын удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ хадалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Татварын тухай хууль
- Нийгмийн даатгалын тухай хууль



Тайлант хугацаанд санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- ✓ Нийгмийн даатгалын ерөнхий хууль 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөгдсөн
- ✓ Татварын ерөнхий хуульд 2024 оны 01 дүгээр сарын 12-ны өдөр, 05 дугаар сарын 16-ны өдөр, 06 дугаар сарын 05-ны өдөр, 11 дүгээр сарын 21-ний өдөр
- ✓ Хөдөлмөр ,нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны 2024 оны 10 дугаар сарын 07-ны 3 дугаар тогтоолоор улсын хэмжээнд мөрдөх хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн сард 792.0 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоосон.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Увс аймгийн Шинэ-Улаангом ОНӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны 03 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 142,840.5 мянган төгрөгөөр буюу 8.1 хувиар буурсан байна.

#### Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	388.0	1,757.8	1,369.8
Авлага	1,080.0	19,602.8	18,522.8
Урьдчилж төлсөн зардал	4,275.0	0.00	-4,275.0
Бараа материал	2,080.0	7,280.0	5,200.0
Үндсэн хөрөнгө	1,704,447.2	1,561,730.7	-142,716.5
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1,784,976.5</b>	<b>1,667,639.7</b>	<b>-117,336.8</b>
Өр төлбөр	360,410.7	319,037.7	- 41,340.7
Эздийн өмч	1,424,565.7	1,348,601.9	5,963.8
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>1,784,976.5</b>	<b>1,667,639.7</b>	<b>-117,304.4</b>

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл нь өмнөх оны үзүүлэлтээс 1,369.8 мянган төгрөгөөр өссөн байна.

Авлага дансны үлдэгдэл 19,602.8 мянган төгрөг болж 18,522.8 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь түрээсийн авлага 5,160.8 мянга, хувь хүнээс авах авлага 14,442.0 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 7,280.0 мянган төгрөг болж 5,200.0 мянган төгрөгөөр өссөн нь худалдаж авсан бараа материал байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,633,730.7 мянган төгрөг болж, 142,840.5 мянган төгрөгөөр буурсан нь элэгдлийн зардал өссөнтэй холбоотой байна.

Эздийн өмч дансны үлдэгдэлд өөрчлөлт ороогүй шалтгаан хөрөнгө шатсантай холбоотой.

### **3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Шинэ Улаангом ОНӨААТҮГ нь санхүүгийн төлөвлөгөө, техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоолоор Шинэ Улаангом ОНӨААТҮГ-ын 2025 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг баталсан байна.

Шинэ Улаангом ОНӨААТҮГ нь тайлант оны нийт орлогыг 769,512.0 мянга, зарлагыг 756,130.3, мянга, нийт ашгийг 13,381.7 мянган төгрөг байхаар төлөвлөсөн байна.

Шинэ Улаангом ОНӨААТҮГ нь гүйцэтгэлээр 707,573.5 мянган төгрөгийн орлого бүрдүүлж 707,154.4 мянган төгрөгийн зардал гарган 419.1 мянган төгрөгийн татварын өмнөх ашигтай ажилласан байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Увс аймгийн Шинэ Улаангом ОНӨААТҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баян жанжин хишиг аудит ХХК-ийн аудитор А.Дугармаа гүйцэтгэж, хяналтыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын ахлах аудитор Б.Авирмэд, менежер М.Бат-Амгалан дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Увс аймгийн Шинэ Улаангом ОНӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баян жанжин хишиг аудит ХХК-д 2026 оны 02 дүгээр сарын 15-ний өдрийн 08 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

20

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
ХЯЛГААРЛАЛТЫН  
СЭВЭЛ ДҮГНЭЛТ

## **4.2 Материаллаг байдал**

Материаллаг байдлыг тооцох эх сурвалжийг ОНӨААТҮГ-ын хувьд суурь үзүүлэлтийг 2025 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн удирдлага, борлуулалтын зардлын дүнгээр сонгох нь зохимжтой гэж дүгнэлээ.

Материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэлж, материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоож, сонгосон суурь үзүүлэлтээс тооцож төлөвлөлтийн материаллаг байдлыг 6,978.4 мянган төгрөгөөр тогтоож баримтжууллаа.

Санхүүгийн тайлангийн түвшинд гүйцэтгэлийн төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 5,582.7 мянган төгрөгөөр тогтоолоо.

## **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Увс аймгийн Шинэ Улаангом ОНӨААТҮГ-ын хувьд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хамаарах зүйл заалтын хүрээнд горим сорил хэрэгжүүлсэн.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил гараагүй болно. /АБ-4/

## **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд оруулбал зохих 149 мэдээллээс байршуулах хугацаа болоогүй 5, хугацаандаа оруулсан 152, хугацаа хоцроож 4 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.


### **4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Төрийн аудитын байгууллагаас 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитаар баримтлах ерөнхий чиглэлд тусгагдсан болон бусад хууль тогтоомжтой холбоотой хэрэгжүүлсэн горим сорилын хүрээнд зөрчил илрээгүй болно.

## **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Увс аймгийн Шинэ Улаангом ОНӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй болно.

### **4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**



Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж, төлбөрийн акт, өгөөгүй байна.

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Увс аймгийн Шинэ Улаангом ОНӨААТҮГ-ын хувьд дараагийн аудитаар хөрөнгийн асуудлыг харж үзэх шаардлагатай гэж үзлээ.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 1 зөрчил илэрсэнд зөвлөмж өглөө.

#### 5.1 Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал

##### 1.1 Илрүүлэлт:

Шинэ Улаангом ОНӨААТҮГ нь 2,388,562.9 мянган төгрөгийн анхны өртөгтэй Худалдааны төвийн барилга 2025 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр шатсантай холбогдуулан эрх бүхий байгууллагын дүгнэлт, шийдвэр гараагүй тул үл хөдлөх хөрөнгийн бүртгэлд өөрчлөлт оруулаагүй байна.

##### Өгсөн зөвлөмж:

Эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэрийг үндэслэж үндсэн хөрөнгийн бүртгэлд өөрчлөлт оруулах.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч ажиллах арга хэмжээний төлөвлөгөөг хуульд заасан хугацаанд, зөвлөмжийн биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн дотор Увс аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

### 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

#### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл


/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дүн												

#### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил	Үүнээс				
		Төлбөрийн акт	Албан шаардлага	Зөвлөмж	Хариуцлага тооцуулах албан шаардлага	Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал



	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн				
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил												
Дүн												
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил												
Дүн												
Нийт дүн												

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:



ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

БЭЛТГЭСЭН: БАЯН ЖАНЖИН ХИШИГ АУДИТ  
ХХК-НИЙ ЗАХИРАЛ, АУДИТОР



/М.БАТСУУРЫ/

/М.БАТ-АМГАЛАН/

/А.ДУГАРМАА/

2026 оны 03 дугаар сарын 11-ны өдөр